

Шатамхай тоосонцрын аюул хаана ч байж болзошгүй! 2021 оны 6-р сар



Зураг 1: CSB Тоосонцроос үүдэлтэй дэлбэрэлт
 (эх үүсвэр: https://www.csb.gov/assets/1/6/csb_dust_incidents.pdf)

АНУ-ын Химийн Бодисын Аюулгүйн Зөвлөл (ХБАЗ) 2006-2017 онд тохиолдсон тоосонцроос үүдэлтэй 105 ослын мэдээллийг цуглуулсан. ХБАЗ тус хугацааны бүх ослыг судлаагүй ба дээрх мэдээллийг хэд хэдэн төрлийн үйлдвэрлэлийн салбараар ангилан ялгаж үзсэн.

ХБАЗ-ийн графикийг харахад шатамхай тоосонцроос үүдэлтэй дэлбэрэлт олон янзын үйлдвэрлэл, үйл ажиллагаанд тохиолддог аж. Химийн бодис үйлдвэрлэлийн салбарт цөөн тооны дэлбэрэлт судлагдсан байгаа хэдий ч хатуу ширхэглэг боловсруулах процесс үйлдвэрлэлийн дамжлагын хаана ч байж болох ба энд түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн бий болдог.



Зураг 2: Гадагш чөлөөлөгдсөн тоосонцор тасралтгүй шатсаар байна.



Зураг 3: Дэлбэрэлтийн үеийн агаар зайлуулах цэгийн анхааруулах тэмдэг

Та мэдэх үү?

- Тоосонцроос үүдэлтэй дэлбэрэлт үүсэх таван нөхцөл байдаг:
 1. Шатамхай тоосонцор;
 2. Тоосонцор агаарт тогтох;
 3. Исэлдэлт;
 4. Тоосонцор хязгаарлагдмал орчинд хуримтлагдах;
 5. Гал ноцоох эх үүсвэр;
- Шатамхай тоосонцрууд үйлдвэрийн янз бүрийн хэсэгт байх боломжтой. Сантехник, бохирын хоолой гэх мэт таны төсөөлөөгүй цэгт ч байж болзошгүй. Хүний гар хүрдэггүй цэгүүдэд нүдэнд үзэгдэхгүйгээр шатамхай тоос хуримтлагдаж болно.
- Тоос соруулах коллекторууд нь дэлбэрэлтийн эх үүсвэр болох тохиолдол түгээмэл байдаг. Тэд хамгийн жижиг ширхэглэгүүдийг цуглуулсаар асар том хэмжээний дэлбэрэлт үүсгэх боломжтой. Коллекторуудад ихэвчлэн дэлбэрэлтийн үеийн агаар зайлуулах буюу хэт даралтыг чөлөөлөх самбар угсарсан байдаг. (Зураг 2).
- Засвар үйлчилгээ, хийц үйлдвэрлэх хэсгийн зүсэлт, өнгөлгөөний цэгт шатамхай металл бүхий тоосонцрууд бий болдог.

Тоосонцроос үүдэлтэй дэлбэрэлтээс сэргийлэх зарим стратеги:

1. Тоос бүү хуримтлуул. (Цэвэрлэгээний тухай Beacon 20-01-ийг унш).
2. Тоос соруулдаг системүүд ашиглан тоосыг голомт дээр нь бууруул.
3. Гал ноцоох боломжтой эх үүсвэрүүдийг тодорхойлж, устга.

Та юу хийж болох вэ?

- Компани эсвэл хэлтсийн цэвэрлэгээний журмыг мөрд. Тоос хуримтлагдаж байгааг ажиглавал ахлах ажилтандаа мэдэгд.
- Тоос соруулах коллекторын ойр ажиллахдаа дэлбэрэлтийн үеийн даралт чөлөөлөх самбар нь хаана байгааг шалгаж, тэндээс аль болох зайлсхий. Даралт чөлөөлөх самбарт тэмдэг тэмдэглэгээ байрлуулах хэрэгтэй. (Зураг 3).
- Даралт чөлөөлөх самбарын эргэн тойронд шугам хоолой гэх мэт саад учруулах зүйлс байрлуулахыг хориглоно. Даралт чөлөөлөх бүсэд бусад төрлийн материал хадгалж болохгүй.
- Таны ажлын талбай дээрх хатуу ширхэглэгтэй бодисуудын шинж чанарын тухай мэдэж, ХАЛ-ны заавар, бусад журмыг мөрд.
- Тоног төхөөрөмжөөс тоосонцор гарч байвал ахлах ажилтанд мэдэгд.
- Тоосонцрын аюулын тухай ХБАЗ-ийн бичлэгийг үзнэ үү: <https://www.csb.gov/videos/combustible-dust-an-insidious-hazard/>

Тоосонцроос үүдэлтэй дэлбэрэлтийн аюулыг бүү огоор!